



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/624

Улаанбаатар хот

Ажлын цагийн хуваарийн тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3. дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2015 оны "Арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай" 03 дугаар захирамж, Монгол улсын Засгийн газрын 2014 оны "Эрх шилжүүлэх тухай" 393 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын анхны ардчилсан, чөлөөт сонгууль явагдсан түүхэн үйл явдлын 25 жилийн ойн баярыг 2015 оны 07 дугаар сарын 29–30-ны өдрүүдэд улс орон даяар зохион байгуулахтай холбогдуулан Нийслэлийн замын хөдөлгөөний ачааллыг тэнцвэржүүлэх, түгжрэл саатлыг бууруулах, баярын арга хэмжээнд уригдан оролцож буй гадаад, дотоодын зочин төлөөлөгчдийн зочлох таатай орчинг бүрдүүлэх зорилгоор нийслэлд байршин үйл ажиллагаа явуулдаг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, бүх шатны төсөвт байгууллагаудын 07 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд ажил эхлэх, дуусах цагийг хавсралтаар баталсугай.

2. Захирамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/, Улаанбаатар хотын Цагдаагийн газар /Ч.Болдбаатар /-т тус тус даалгасугай.


3. Батлагдсан цагийн хуваарийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд шуурхай мэдээлж сурталчлахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс /Я.Мөнгөнцэцэг/-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Э.БАТ-ҮҮЛ

Нийслэлийн Засаг даргын 2015 оны  
*07 дугаар*...сарын *30*-ны өдрийн  
*А/624 дугаар*...захирамжийн хавсралт



2015 ОНЫ 07 ДУГААР САРЫН 30-31-НИЙ ӨДРҮҮДЭД  
НИЙСЛЭЛД БАЙРШИН АЖИЛЛАДАГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН  
АЖИЛЛАХ АЖЛЫН ЦАГИЙН ХУВААРЬ

№	Он сар өдөр	Ажил эхлэх цаг	Ажил дуусах цаг
1	2015 оны 07 дугаар сарын 30-ний өдөр	08.30 цаг	12.30 цаг
2	2015 оны 07 дугаар сарын 31-ний өдөр	10.00 цаг	17.30 цаг